



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны ᠐᠖ сарын ᠐᠘ өдөр

Дугаар ᠒/80

Улаанбаатар хот

Нийслэлийн Хот байгуулалт, хотын
стандартын газрын эргэлтийн бус хөрөнгийг
балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 794,394.00 (долоон зуун ерэн дөрвөн мянга гурван зуун ерэн дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Хяналт шалгалтын газрын баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Баярсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 01 -ны өдрийн 1/08 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Шилжүүлэн авах байгууллага
1	Ширээ ажлын	2009	ш	1	794,394.00	794,394.00	Нийслэлийн Хяналт шалгалтын газар
НИЙТ ДҮН						794,394.00	